

БАТЛАВ
СҮХБААТАР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГА Б.МӨНХ-ЭРДЭНЭ

2025 оны 09 дугаар сарын 4 өдөр

1117143195 9085062

СҮХБААТАР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Зорилго

Байгууллагын урт хугацааны зорилго, хөгжлийн чиглэлтэй нийцүүлэн ажиллах хүчийг үр ашигтайгаар удирдаж, байгууллагын амжилтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн байх. Энэ стратеги нь ажилтнуудын ур чавдар, бүтээмжийг тасралтгүй сайжруулж, хүний нөөцийн чадамжийг дээд түвшинд хүргэх зорилготой.

2. Үндсэн зарчим

Хүний нөөцийн хөгжүүлэлт: Ажилтнуудын мэдлэг, ур чавдарыг байнга дээшлүүлэх сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.

Шударга цалин хөлс, урамшууллын систем: Цалин, урамшууллыг ажилтны амжилт, гүйцэтгэлд үндэслэн шударга, ил тодоор үнэлэх дүгнэх.

Ажилчдын сэтгэл ханамж: Албан хаагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлж, урт хугацаанд тогтвортой ажиллах ажлыг орчин нөхцөлийг бүрдүүлэх.

Идэвхжүүлэлт ба оролцоо: Ажилтнуудыг шийдэр гаргалтанд идэвхтэй оролцуулж байгууллагын соёлд нийцүүлэх.

3. Хүний нөөцийн хөгжлийн стратеги

Сургалт, хөгжил: Тухайн ажилтны мэргэжил, ур чадварыг сайжруулах, ажлын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын тогтолцоог хөгжүүлнэ.

Дотоод карьерт төсөл: Байгууллагад дэвших боломжийг тодорхой болгож, ажилтнуудын карьерт өсөн дэвших замыг нээх.

Мэргэшил олгох: Ажилтнуудыг мэргэшүүлэх, олон улсын стандартуудыг мөрдөх, мэргэшлийн үнэмлэх авахад дэмжлэг үзүүлэх.

4. Ажилд авах стратеги

Байгууллагын соёлд нийцэх, чадварлаг мэргэжилтнүүдийг хайж ажилд авах үйл явцыг үр ашигтай зохион байгуулах.

Тэгш байдал ба олон талт байдал: Ажилд авахдаа тэгш боломж олон талт байдлыг хангах, нас, хүйс, шашин шүтлэг, нийгмийн гарал үүсэл гэх мэт үзүүлэлтээр ялгаварлахгүй байх.

5. Хөмөлмөрийн харилцаа

Эв нэгдэлтэй ажлын орчин: Ажилтнуудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааг дэмжиж, найрсаг, эв нэгдэлтэй ажлын орчинг бүрдүүлэх.

Эрүүл аюулгүй орчин: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан байр талбайгаар ажилтнуудын ажиллах орчныг бүрдүүлэх.

6. Стратегийн хэрэгжилт

Үнэлгээ сайжруулалт: Хүний нөөцийн бодлого, стратегийн хэрэгжилтийг тогтмол үнэлж, шинэчлэлт, сайжруулалтыг тогтмол хийх.

Хамтын ажиллагаа: Байгууллагын удирдлага болон ажилтнууд хамтран хүний нөөцийн стратерийг хэрэгжүүлэх.

СҮХБААТАР ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРОО